


Сэдэв: Авто замын ТЭЭВЭРЛЭЛТ



Олон улсын авто замын ачаа тээвэрлэлт гэдэг нь төрөл бүрийн ачаа тээх зориулалт бүхий авто машиныг ашиглан, 2 буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэрийг дамжин, нийлүүлэгчээс хүлээн авагчид ачаа барааг хүргэж өгөх үйл ажиллагаа юм





Авто замын тээвэр нь хаалганаас хаалганд хүртэл тээвэрлэлт хийх чадвартай, өөрөөр хэлбэл ачилт буулгалт хийх тусгай буудал, боомтыг шаардаад байдаггүй, нийлүүлэгчийн үйлдвэр агуулахаас хэрэгчид шууд хүргэж өгөх боломжтойгоороо тээврийн бусад хэлбэрээс давуутай

- Хаалганаас хаалганд буюу үйлдвэрлэгчийн үйлдвэр агуулахаас хэрэглэгчийн хаа байгаа газар хүртэл тээвэрлэлт хийх боломжтой, уян хатан
- Эд бараа, бүтээгдэхүүний эвдрэл, алдагдал бага
- Ойрын зайд бага хэмжээний бараа бүтээгдэхүүнийг хямд өртгөөр тээвэрлэх боломжтой
- Тогтмол болон хэрэгтэй үедээ тээвэрлэлтийг хялбархан зохион байгуулах боломжтой
- Тээвэрлэлтийн явцад сэлгэн ачилт бага. Сав баглаа боодлын хувьд амар энгийн
- Тусгайлсан буудал, ачиж буулгах цэг байгуулах шаардлагагүй
- Цаг агаарын нөлөө бага

- Тээврийн зардал өндөр
- Нэг удаа тээвэрлэх хэмжээ бага
- Зам тээврийн осол гарах магадлал их

- Ачаа барааг цуглуулж тээвэрлэх буюу цуглуулбар тээвэрлэлт:
Ачаа барааг илгээгчдээс цуглуулан авч ачиж буулгах цэг хүртэл, ачиж буулгах цэгээс ачаа барааг хүлээн авагчдад хүлээлгэн өгдөг тээвэр
- Шууд бус тээвэрлэлт:
Ачиж буулгах цэгээс очих газрын ачиж буулгах цэг юм уу эсвэл үйлчлүүлэгчийн гэрт нь холын зайны овор ихтэй, том барааг хүргэж өгдөг. Дунд юмуу том оврын тээврийн хэрэгсэл шаарддаг
- Чиглэлт тээвэрлэлт:
Урьдаас тогтоосон чиглэлийн дагуу тодорхой төлөвлөгөөтэй хийж буй тээвэрлэлт
- Хүргэж өгөх тээвэрлэлт:
Ачаа барааг хүлээн авагчид дамжуулан өгдөг тээвэр. Ачиж буулгах цэгээс эсхүл бусад тээврийн хэрэгслээс дамжуулан тээвэрлэж болно

- Автомашиныг ашиглан улс дотроо дотоодын тээвэрлэлтэд болон улс дамнан гадаад худалдаанд ч ашиглаж байгаа нь авто тээврийн олон талт байдалтай холбоотойгоос гадна зам харилцаа сайжирч, авто тээвэрлэлтийг зохицуулах олон улсын эрхзүйн зохицуулалт улам бүр боловсронгуй болж байгаатай холбоотой
- Монгол Улс дараах конвенциудад нэгдээд байна
- Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенци
- Замын хөдөлгөөний тухай конвенци
- Тир карнейн хүрээнд барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенци

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

